



Түлхүүр мэдээлэл

- Монгол улсын хүнсний ногооны ургац хөрш орнуудаасаа харьцангуй бага байна.
- Өртгийн сүлжээний ойлгомжгүй байдал нь ХАА-н үйлдвэрлэлд хийх хөрөнгө оруулалтыг багасгаж улмаар үйлдвэрлэлийн өсөлтөд саад учруулж байна.
- Мүү хөгжүүлсэн өртгийн сүлжээ нь үйлдвэрлэлийн орцыг бууруулах, нэвтрүүлэх үйлчилгээний хүрээг багасгах, агуулах зоорийг хүрэлцээгүй болгох, бүтээгдэхүүнийг албан бусаар борлуулах явдлыг өөгшүүлэх зэргээр Монголын ногоочдыг эрсдэлд өртөмтгий болгож байна.
- Хүнсний ногооны эрсдэлийн одоогийн удирдлага нь орон нутагт тохирсон үйлчилгээ байхгүйгээс шалтгаалан орчин үеийн аргачлалыг бараг ашиглагддаггүй тул хоцрогдсон байдалтай байна.
- Дижиталчлалыг нэвтрүүлэх нь нийлүүлэлтийн сүлжээн дэх бэрхшээлүүдийг даван туулах боломжийг олгон, хүнсний ногоо үйлдвэрлэгчдийн эрсдэл тэсвэрлэх чадварыг сайжруулна.
- Гар утасны аппликэйшн хэрэглэх нь нийлүүлэлтийн онлайн сүлжээ ба нэвтрүүлэх үйлчилгээг үүсгэх хамгийн хурдан, хямдхан арга юм.
- Эрсдэлийн удирдлагын арга дээр үндэслэсэн, Монгол ногоочин бүрийн хэрэгцээнд тохирох эрсдэлийг бууруулах бодлого хэрэгтэй байдалд үнэлгээ өгөхийн тулд илүү судалгаа хийх шаардлагатай байна.

Монголын хүнсний ногоо үйлдвэрлэгчдэд тулгарч байгаа зах зээл ба үнийн эрсдэл – Үйлдвэрлэлийн огцом өсөлтийг даах чадварыг нэмэгдүүлэх нь

Оршил

Сүүлийн жилүүдэд хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, орон нутаг дахь үнийг бууруулах нь Монгол улсын засгийн газрын чухал зорилт болоод байна (АХБ, 2020). Монгол улсын хувьд хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах явдал нэмэгдэж байгаа талаар Азийн Хөгжлийн Банкнаас мэдээлсэн ба энэ нь бодлогын чанартай хөтөлбөрүүд хэрэгжсэний үр дүнтэй холбоотой байх магадлалтай юм. Гэхдээ, хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх олон хөтөлбөр, сайн хандлага их байгаа боловч өнгөрсөн хугацаанд үйлдвэрлэл болон хэрэглээ нь бага хэмжээгээр нэмэгдсэн байна (АХБ, 2020).

Үйлдвэрлэлийн өсөлт удаан байгаа үндсэн шалтгаан нь Хятад, Казакстан, Орос гэх мэт хөрш орнуудтай харьцуулахад Монгол улсын хүнсний ногооны ургац бага байдагтай холбоотой юм. Мөн, сүүлийн хорин жилийн туршид Монгол улсын хүнсний ногооны ургацын хэмжээнд бараг өсөлт ажиглагдаагүй, эсвэл дөнгөж ашиг олох төдий хэмжээний өсөлттэй байсан бол энэ хугацаанд бусад орнуудын ургацын хэмжээ 200 гаруй хувиар нэмэгдсэн байв (ХХААБСТАТ, 2020).

Санхүүжүүлэлт хийсний үр дүнд ашиг олох эсэх нь тодорхой бус байгаа явдал нь хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, ногоочдыг төрөл бүрийн эрсдэлд өртөмтгий болгосноор энэхүү зогсонги байдал үүсгэхэд хүргэсэн байж болзошгүй юм. Энэ бодлогын зөвлөмж бичигт эрсдэлийн мэдрэмжийн олон талын судалгааны үр дүнгээс гадна одоо мөрдөж байгаа зах зээлийн эрсдэлийг бууруулах, түүнд дасан зохицох бодлогын талаар танилцуулсан болно. Энд тусгасан хэлэлцүүлэг нь 2020 онд Монгол улсын өөр өөр бүс нутгийн 308 ногоочдыг хамруулсан судалгаан дээр үндэслэн хийгдсэн болно.



Тусгай таримал, үйлдвэрлэлийн хандлага - хүнсний ногооны хязгаарлагдмал нэр төрөл

Судалгаанд оролцсон хүнсний ногоо үйлдвэрлэгчид нь нийт найман аймгийн төлөөлөл бөгөөд Монгол улсын хэмжээнд томд тооцогддог хүнсний ногоо тариалдаг гол нутгуудад харьяалагддаг болно. Тус ногоочдыг тариалангийн үйл ажиллагааны чиглэлээр нь хувааж үзвэл, гуравны хоёр нь өрхийн тариаланчид, зургааны нэг нь хоршоолсон үйлдвэрлэл эрхлэгчид, үлдсэн хувь нь тариалангийн аж ахуй эрхлэгчид байв. Эдгээр тариаланчдын ургацын мэдээг харахад зарим ногооны хувьд хэлбэлзэлтэй ч хоршоолсон үйлдвэрлэл эрхлэгчид нь өрхийн тариалан болон тариалангийн аж ахуй эрхлэгчдээс илүү хэмжээний ургац хурааж авдаг болох нь харагдаж байна. Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн тоо (244 аж ахуй төмсийг, 201 аж ахуй лууванг) болон ургацын хэмжээг (төмс - 25.4 мянган тонн, лууван - 5.5 мянган тонн) харвал төмс болон лууван нь эдгээр хүнсний ногоо үйлдвэрлэгчдийн голлон тариалдаг үндсэн таримлууд бөгөөд үүнээс гадна, сонгино, байцаа, манжин, урт болон богино өргөст хэмхийг мөн их хэмжээгээр үндсэн тарималд тооцон тариалдаг байна.

Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйд нь дунджаар хоёроос гурван төрлийн хүнсний ногоо тариалдаг бөгөөд 90% орчим нь хүнсний ногооны нэр төрлийг нэмэгдүүлсээр орлогоо нэмэгдүүлэх боломжтой гэж үзсэн явдал нь тэд олон нэр төрлийн хүнсний ногоо тариалахын ач тусыг ойлгож байгаа болохыг илэрхийлж байна. Тариаланчдаас одоо тариалж байгаа таримлын бүрэлдэхүүн үйлдвэрлэлийн талаар асуухад талаас илүү хувь нь сэтгэл хангалуун байгаа гэсэн бол 45% нь нэр төрлийг нь илүү ихээр нэмэгдүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлэв. Тэднээс таримлын нэр төрлийг нэмэгдүүлэхэд саад учруулж байгаа голлох шалтгаануудыг нь асуухад нийт оролцогчдын 65% нь тохиромжтой тоног төхөөрөмж хомстол, 60% нь үнийн тогтворгүй байдал, 50% нь зээл авахтай холбоотой хүндрэл, 40% нь өрхийн хөдөлмөрийн оролцоо бага байдагтай холбон хариулсан байна. Мөн, үйлдвэрлэлийн хэмжээ ба зах зээл нэмэгдэхэд гарах эрсдэл, тариаланд тохиромжтой газар нутгийн хомстол, шаардлагатай хөрөнгө оруулалт хийх санхүүжилтийн дутагдал, ажиллах хүчний хомстол зэрэг бэрхшээлүүд байдаг талаар дурдсан юм. Ялангуяа “үнийн тогтворгүй байдал” болон олон төрлийн таримал тариалахад тохиолддог нэмэгдэл эрсдэлийн талаар ил тодоор илэрхийлж байсан нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлд тулгардаг ерөнхий бэрхшээлүүдээс гадна цаашид хүнсний ногооны тариаланд тохиолдож болох тодорхой бус хүчин зүйлээс шалтгаалж гарах бэрхшээлүүд тулгарч болшгүй байгааг харуулж байна.

Эрсдэлийн мэдрэмж – үнийн болон зах зээлийн эрсдэлийн давамгайл байдал

Зураг 1-т үзүүлснээр үнэ болон зах зээлийн эрсдэл нь Монголын хүнсний ногоо үйлдвэрлэгчдийн хувьд хамгийн хүнд эрсдэлүүдэд тооцогддог байна. Үнэ болон зах зээлийн эрсдэлүүд нь бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувьд бүтээгдэхүүнийхээ зах зээлийн үнийг мэдэх үед, эсвэл үйлдвэрлэлийн орцод зориулан зардал гаргах үед тулгардаг ойлгомжгүй нөхцөлд тохиолддог

(Хардакер, 2004). Судалгааны ярилцлагад хамрагдсан 308 тариаланчдын хувьд хамгийн их дурдагдсан эрсдэл нь үнэ болон зах зээлийн эрсдэл байсан юм. Тухайлбал, нийт оролцогчдын 79% нь “ногооны зах зээлийн үнийн хөөрөгдөл”-ийн талаар, 71% нь “ажиллах хүчний дутагдал”-ын талаар, 22% нь “инфлац”-ийн талаар дурдсан байна. Хоёрдахь хамгийн их дурдагдсан эрсдэлийн бүлэгт үйлдвэрлэлийн эрсдэл, тухайлбал, “хур тунадасны хомстол” (нийт оролцогчдын 64%), зуны их халалт (нийт оролцогчдын 54%), “улирлын чанартай ширүүн бороо/үер” (нийт оролцогчдын 49%) зэрэг хүчин зүйлс орсон байна. Харин дээрх эрсдэлүүдийг бодвол нөлөөлөл харьцангуй багатай эрсдэлүүдэд “барьцааны төлбөр болон зээлээ төлөх чадваргүй болох” байдлаар илрэх санхүүгийн эрсдэл (нийт оролцогчдын 13%), “өвчний үлмаас хөдөлмөрийн чадвараа алдах” байдлаар илрэх хувь хүний эрсдэл (нийт оролцогчдын 7%), “хууль дүрэм өөрчлөгдөх” –д илрэх байгууллагын эрсдэл (нийт оролцогчдын 1%) зэрэг оржээ. Монголын хүнсний ногоо үйлдвэрлэгчдийн зах зээл болон үнийн эрсдэлд өртөмтгий байгаа нь нийлүүлэлтийн сүлжээний ойлгомжгүй, үр ашиггүй байдлаар голчлон тайлбарлагдана. Энэ талаар доор илүү дэлгэрэнгүй байдлаар тайлбарласан болно.



Зураг 1: Өнгөрсөн 10 жилд тулгарсан эрсдэлүүд

Эх сурвалж: Өөрсдийн хийсэн судалгаа

Нийлүүлэлтийн сүлжээ – шинэчлэл хийж ойлгомжгүй байдлыг бууруулах нь

Тариаланчдын хувьд ургац хураасны дараах хамгийн чухал, эрсдэлтэй ажил нь бүтээгдэхүүнээ борлуулах явдал юм. Судалгаанд оролцсон ногоочдын тал орчим хувь нь бүтээгдэхүүнээ орон нутгийн зах зээлд албан ёсны дүрэм журамгүйгээр шууд борлуулдаг. Энэ байдал нь хүнсний ногоог



богино хугацаанд борлуулах шаардлага, ердийн захуудад хөргөх байгууламж байхгүйгээс шалтгаалан хорогдол гарах эрсдэлийг дагуулдаг (Хүснэгт 1). Нийт хэрэглэгчдийн 11% нь өөрсдөө ирж худалдан авалт хийдэг явдал нь тариаланчдыг тээвэрлэлтийн зардлаас ангижруулах боловч энэ нь борлуулалтын явцад тулгардаг цаг хугацааны дарамтыг хөнгөвчлөхгүй юм. Тиймээс агуулах зооринд хөрөнгө оруулах шаардлагатай бөгөөд ингэснээр хэрэглэгчдийн зүгээс бүтээгдэхүүнийг ирж авахад гардаг гологдолтой холбоотой эрсдэлийг багасгана. Зах зээлийн үнийн хэлбэлзлээс хамгаалах чухал арга болох гэрээт тариалан эрхлэх явдал тун ховор байна. Судалгаанд хамрагдсан нийт тариаланчдын зөвхөн 8% нь энэ нөхцөлийг ашиглан үйлдвэрлэлээ эрхэлдэг гэсэн юм. Ийм байдал хөгжил буурай зах зээлийн бүтцэд түгээмэл тохиолддог. Тухайлбал, Хятад улсад 2000 оны үед хийгдсэн судалгаанаас үзэхэд ногоочид нийт бүтээгдэхүүнийхээ 70%-ийг нь өөрсдөө зах зээлд хүргэж өгдөг байсан бөгөөд тухайн бүтээгдэхүүний ихэнх хэсэг нь бөөний худалдааны төвүүдээр тараагддаг байжээ (Юуман, 2004). Харин сүүлийн жилүүдэд худалдан авагчдад зориулсан бүтээгдэхүүний чанарын мэдээлэл илүү ил тод болсноор ногоочдын гар дээрээс бүтээгдэхүүний нийлүүлэлтийг шууд хийх нь Хятад улсад илүү чухал болсон байна (Лю, 2007). Үүнтэй ижил хөгжил нь Монгол улсын хүнсний ногооны тариаланг бэхжүүлэх бөгөөд ингэснээр ногоочид нь өөрсдөдөө тулгардаг эрсдэлийн зарим хэсгийг худалдан авагч нарт шилжүүлэх боломжтой болох юм.

Тариалан эрхлэх хэлбэрүүдийн ялгааг ойлгох судалгаанд хамрагдсан тариалангийн аж ахуй эрхлэгчдийн (нийт оролцогчдын 28%) дийлэнх нь гэрээт тариалан эрхлэх төрлийг сонгосон бол харин бусад нь тариаланчид энэ төрлийг бараг сонгоогүй байна. Харин судалгаанд хамрагдагчдын 24% нь борлуулалтын хоршоонд нэгдэн ажиллах төрлийг сонгосон бөгөөд энэ нь худалдан авагчтай холбоотой гарах бэрхшээлийг бие даасан аж ахуйн нэгжид шилжүүлэх боломжийг олгох юм. Борлуулалтын хоршоонд хамрагдах төрлийг бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхэлдэг хоршоодын гишүүдийн ихэнх нь хэрэгжүүлдэг гэсэн бол харин өрхийн тариаланчдын 10%, тариалангийн аж ахуйдын 12% нь л хэрэгжүүлдэг гэсэн байна. Өрхийн тариаланчдын хувьд (62% нь) эрсдэлийн тодорхой нэг хэсгийг хянахад давамгайл хэрэглэгддэг арга нь бүтээгдэхүүнээ дундын зуучлагчид (ченжээр) зарах явдал гэж үзсэн юм. Ингэснээр хэрэглэгч нэг бүртэй цаг зарцуулж хэлэлцээр хийхэд гарах эрсдэлийг өөр оролцогчид буюу ченжид шилжүүлэх боломж бүрдэнэ. Үүнтэй нэгэн адилаар Хятад улсын томоохон тариалан эрхлэгчид нь гэрээт тариалан эрхлэх байдлыг эрсдэлийн удирдлагын хэрэгсэл гэхээс илүү бүтээгдэхүүний өндөр үнийг хамгаалах, гүйлгээний зардлыг бууруулахтай холбон тайлбарладаг байна (Холли Ванг, 2011).

Өрхийн тариаланчдын хувьд эрсдэлийг хуваалцах дээрх байдлаас өөр аргуудыг бараг ашигладаггүй байна. Албан ёсны гэрээт хэлэлцээр (бичгэн гэрээ) хийх нь бүх төрлийн тариалан эрхлэгчдийн дунд сайн хөгжөөгүй байгаа явдал нь түүвэр судалгаанд оролцсон тариаланчдын зөвхөн 15% нь л энэ аргыг ашигладаг гэсэн байдлаас харагдаж байна. Албан ёсны гэрээ хийдэг гэж тариалангийн аж ахуйдын 33% нь илэрхийлсэн (хамгийн их хувь) бол өрхийн тариаланчдын 7% нь

л (хамгийн бага хувь) ийм гэрээ хийдэг гэжээ. Албан ёсны гэрээ хийх түвшин бага байгаа явдал нь тариаланчдыг, ялангуяа худалдаа хийх чадвар муутай, албан бус хэлэлцээрээр борлуулалтаа хийдэг жижиг өрхийн аж ахуйдыг зах зээлийн эрсдэл болон богино хугацааны үнийн хэлбэлзэл эсвэл бизнес хамтрагчдын төлбөр хойшлогдоход өртөмтгий болгодог байна.

Зөвхөн цөөн тооны тариаланчид (судалгаанд хамрагдагчдын 7%) температурын хяналт бүхий агуулах зоорины байгууламжтай гэжээ. Харин үлдсэн тариаланчдын хувьд бүтээгдэхүүнээ борлуулах явцад гарч болох цаг хугацааны алдагдлын эрсдэлээс болон үнэ цэнийн алдагдлаас хамгаалах арга байхгүй гэсэн үг юм. Судалгаанд хамрагдагчдын 69% нь энгийн агуулах, зоорьтой байгаа тул энэ нь үнийн хэлбэлзэл ихтэй үед тариаланчдад хүлээх боломж болон ургацынхаа зарим хэсгийг өөрсдийн хэрэгцээнд зориулан хадгалах боломжийг олгодог байна. Гэхдээ энэ байдал нь бүх бүтээгдэхүүнийхээ үнэ цэнийг урт хугацаанд хадгалахад нь сайн нөлөө үзүүлж чадахгүй юм.

Хүснэгт 1: Нийлүүлэлтийн сүлжээний хүчин зүйлс

	Гишүүнчлэл бүхий борлуулалтын хоршоо	Зах зээлд нэвтрэх боломж					Бичгэн гэрээ	Агуулах, зоорь		
		Зах зээлд шууд борлуулах	Гэрээт тариалан эрхлэлт	Зуучлагчаар (ченжээр) дамжуулах	Хэрэглэгчид өөрсдөө ирж авах	Өөр хоршоогоор дамжуулах		Энгийн	Температурын хяналттай	Байхгүй
Өрхийн тариалан	10.2%	55.8%	3.4%	62.1%	8.7%	4.4%	7.3%	69.9%	3.4%	27.2%
Тариалангийн аж ахуй	11.8%	43.1%	27.5%	64.7%	11.8%	2.0%	33.3%	54.9%	25.5%	19.6%
Үйлдвэрлэл явуулдаг хоршоо	90.2%	35.3%	5.9%	60.8%	17.6%	25.5%	29.4%	76.5%	3.9%	19.6%
Нийт	23.7%	50.3%	7.8%	62.3%	10.7%	7.5%	15.3%	68.5%	7.1%	24.7%

Эх сурвалж: Өөрсдийн хийсэн судалгаа

Үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхийн тулд орцоо сайжруулах нь нийлүүлэлтийн сүлжээнд тулгардаг бас нэг бэрхшээл юм. Судалгаанд хамрагдсан тариаланчдын 66% нь үйлдвэрлэлийн орц худалдан авахад хүндрэл учирдаг талаар мэдүүлсэн байна. Тэдний голчлон мэдээлснээр дэлгүүрт очих боломжгүй (32% нь), очих боломжтой ч шаардагдаж байгаа орц тухайн дэлгүүрт байхгүй (41% нь), байсан ч тухайн шаардагдаж байгаа орцын үнэ өндөр (24% нь) зэрэг хүндрэлүүд дурдагджээ. Үйлдвэрлэлийнхээ орц нэмэгдүүлснээр нь ургацын хэмжээг ихсэж, улмаар газар тариалангийн үйлдвэрлэлийн ашгийг сайжруулдаг. Ингэсний үр дүнд ганд тэсвэртэй шинэ сортуудыг гаргах үйл ажиллагаа ч дэмжигдэх боломж бүрдэх юм. Үйлдвэрлэлдээ тохиромжтой орц худалдан авахад гардаг дээр дурдсан бэрхшээлүүдээс харахад ийм маягийн эрсдэлийн удирдлага нь бидний судалгаандаа түүвэрлэн авсан ихэнх аж ахуйн хувьд хийх сонголт биш болох нь тодорхой байна.



Орц худалдан авахтай холбоотой тодорхой бус байдлаас гадна үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулахтай холбоотой өөр олон эргэлзээтэй асуудлууд байна.

Хүнсний ногооны үйлдвэрлэлтэй холбоотой сүүлчийн чухал хүчин зүйл бол хүлэмжийн технологийг нэвтрүүлэхтэй холбоотой бөгөөд ингэснээр байгалийн тодорхой гамшгийн хор нөлөөг багасгах юм. Хятад улс дахь тариалангийн аж ахуйн системтэй харьцуулах байдлаар судалж үзвэл 2000 оны байдлаар тэдний хүнсний ногооны тариалангийн талбайн 11%-ийг хүлэмжийн тариалан эзэлсэн байв (Лию, 2004). Үүнтэй нэгэн адилаар түүвэр судалгаанд хамрагдсан Монгол улсын тариаланчдын цөөн хувь нь хүлэмжийн технологийг ашиглаж байна. Судалгаанд хамрагдсан тариаланчдаас дөнгөж 40 нь буюу гол төлөв том тариалан эрхлэгчид нь хүлэмжийн үйлдвэрлэлийг эрхлэн урт болон богино өргөст хэмхийг ихэвчлэн тариалдаг. Хүлэмжийн үйлдвэрлэлийг нэвтрүүлэхэд нэлээд их хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд үндсэн хөрөнгө ихтэй эсвэл зээл авах чадвар сайтай аж ахуйн нэгжүүдийн хувьд л боломжтой тул цөөн тооны хүлэмжийн аж ахуй эрхлэгчид байгаа явдалд гайхах хэрэггүй юм. Иймээс хүнсний ногооны нэр төрлийг олшруулахад болон хүлэмжийн үйлдвэрлэл гэх мэт технологид хөрөнгө оруулахад тулгуурласан тариалангийн аж ахуйн эрсдэлийн удирдлагатай үндсэн хөрөнгө нь шууд холбоотой болохыг онцлон дурдмаар байна.

Эрсдэл бууруулах болон эрсдэлийн удирдлага

Эрсдэл бууруулах гэдэг нь хор хөнөөлийн нөлөөллийг даван туулах байдлаар тодорхойлогдоно. Нөлөөллийн хор уршгийг даван туулахад хамгийн түгээмэл хэрэглэсэн сонголтуудад хамаатан садан, найз нөхдөөсөө болон банкнаас мөнгөн зээл авах явдал гэж энэ судалгаагаар тогтоогдсон бол харин, малаа зарах, эсвэл газар тариалангийн болон хувийн эд хөрөнгөө зарах явдал нь хамгийн бага тохиолддог уршгийг барагдуулах сонголт юм. Тариаланчид нь зөвхөн онцгой тохиолдолд хэрэглээгээ багасгадаг гэсэн бөгөөд тэдний гэр бүлүүд нь үр хүүхдийнхээ боловсролд зарцуулах зардлыг танахаас зайлсхийдэг байна. Судалгаанд оролцсон тариаланчдын 42% нь ярилцлага авах үед зээлийн үлдэгдэлтэй байгаагаа дурдсан байна. Зээлийн үлдэгдлийн өндөр хувь нь арилжааны зээлийг хамгийн түгээмэл хэрэглэгддэг эрсдэл бууруулах арга зам гэж нотолж байгаа юм. Зээлийн дундаж хүү нь 22%-тай гэж мэдээлсэн нь зээлийн зах зээл хөгжөөгүй орнуудын хувьд түгээмэл түвшин бөгөөд энэ нь тариалангийн аж ахуйдад учрах санхүүгийн дарамт ба зээлээ төлөх чадвараа алдах байдал өндөр байгаагийн илэрхийлэл юм.

Эрсдэлийн удирдлагад тариаланчдын ирээдүйд тохиолдож болох үйл явдлыг даван туулах чадварыг сайжруулахад зориулан авах стратегийн бүх арга хэмжээ ордог. Судалгаанд хамрагдсан ихэнх тариаланчид хураасан ургацынхаа заримыг нь хадгалах, эсвэл бага ургацтай эрсдэл багатай тарималд, усалгааны төхөөрөмжид, олон нэр төрлийн таримал тариалах зэрэгт хөрөнгө оруулалт хийх, тариалан эрхлэхээс өөр ажил хайж олох, банкны хадгаламжаа нэмэгдүүлэх зэрэг эрсдэлийн



удирдлагын уламжлалт стратегийг сонгосон байв. Эрсдэлийн удирдлагын бусад аргууд нь хангалттай хэмжээний хамгаалалт үзүүлдэггүй, эсвэл зардал ихтэй, хэрэглэхэд тохиромжгүй байдаг тул Монголын хүнсний ногоо үйлдвэрлэгчдийн хувьд ач холбогдол багатай байгаа юм. Бидний судалгаанд түүвэрлэн оролцуулсан тариаланчид газар тариалангийн даатгалыг эрсдэлийн удирдлагын арга болгон бараг ашиглахгүй байгаа нь хачирхалтай хэрэг бөгөөд үүнийг даатгалын компаниудын зүгээс хангалттай хэмжээний амлалт өгдөггүй байдалтай холбон тайлбарлаж болох юм. Мөн, урьдчилсан гэрээ байгуулах зэрэг зах зээлд тулгуурласан эрсдэлийн удирдлагын стратегийг бас бараг ашиглахгүй байгааг өмнөх бүлэгт дурдсан нийлүүлэлтийн сүлжээнд албан ёсны хэлэлцээр байхгүй байгаатай холбон тайлбарлаж болно.

Монголын хүнсний ногооны салбарын тэсвэртэй байдлыг сайжруулахад зориулж өгөх зөвлөмж

Зах зээлийн оролцооны нэгдмэл чанар сул байгаа явдал болон хөгжил муутай, албан бүс нийлүүлэлтийн сүлжээ нь Монголын хүнсний ногооны салбарыг үйлдвэрлэл, зах зээлийн эрсдэлд өртөмтгий болгодог. Эдгээр дутагдлуудаас шалтгаалан гүйлгээний зардал өсөж үнийн хэлбэлзлийг эсвэл инфляцийг тэсвэрлэх тариаланчдын чадвар буурдаг байна. Үүнээс гадна, Монгол улсын бараг бүх аймгуудад тулгарч байгаа нэг том бэрхшээл бол орцыг нэмэгдүүлэхтэй холбоотой бөгөөд энэ нь бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах чадварыг бууруулахаас гадна эрсдэлтэй нөхцөлд илүү тэсвэртэй сорт гаргахад хөрөнгө оруулалт хийх боломжийг багасгадаг байна. Монгол улсад хүнсний ногооны салбарыг хөгжүүлэхийн тулд агуулах зоорины хүртээмжгүй байдал эсвэл хүнсний дэлгүүрүүдэд шаардлагатай орц дутагдалтай байгаа зэрэг асуудлуудыг арилгах хэрэгтэй юм. Хөгжил муутай нийлүүлэлтийн сүлжээнүүд нь уур амьсгалтай холбоотой гардаг эрсдэлээс илүүтэйгээр тариаланчдыг зах зээлийн болон үнийн эрсдэлд илүү их өртөмтгий болгодог. Нийлүүлэлтийн сүлжээний ойлгомжгүй байдал болон зах зээлд нэвтрэхэд ашиг муутай байдал зэргийг арилгах боломжит шийдэл нь дижиталчлалыг нэвтрүүлэх явдал юм. Ихэнх тариаланчид шаардлагатай технологиор тоноглогдсон байдаг. Ялангуяа утасны програм гэх мэт Монгол хэл дээрх дижитал үйлчилгээг үзүүлснээр гүйлгээний зардлыг багасгаж мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлнэ. Ялангуяа, алслагдсан газар нутаг дахь тариаланчдийн үнийн мэдээлэл авах боломжийг сайжруулах юм. Энэ судалгааны үр дүнгээс даатгалын зах зээлийг байгуулах явдлыг дэмжих шаардлагатай болох нь тодорхой харагдаж байна. Монголын мал аж ахуйн салбарт хийсэн өмнөх судалгаануудын үр дүнд санхүүгийн эрсдэлийн удирдлагын арга хэрэгслийн хэрэгцээ их байгаа нь тодорхой болсны нэгэн адилаар хүнсний ногоо тариалагчид нь зээл авах эсвэл санхүүгийн бусад дэмжлэгтэй холбоотой асуудлыг ихээр сонирхож байгаа болох нь ажиглагдлаа. Дээр дурдсан сайжруулалт хийх боломжуудыг нарийвчлан судлахын тулд цаашид шинжлэх ухааны судалгаа хийх шаардлагатай байгаа юм. Ялангуяа, Монголын хүнсний ногооны тариаланч бүрийн



хэрэгцээг хангахын тулд хэрэгцээнд тулгуурласан эрсдэлийн удирдлагын арга хэрэгсэл, эрсдэлийг бууруулах стратегийг судалж хөгжүүлэх шаардлагатай.

Ашигласан хэвлэл

- АХБ (2020). "Монгол Улсын Хүнсний Ногооны Үйлдвэрлэлийн Өртгийн Сүлжээ". Азийн Хөгжлийн Банк. Манилла, Филиппин улс.
- ФАОСТАТ (2020). Хүнс, хөдөө аж ахуйн мэдээлэл. Нэгдсэн Үндсэн Байгууллагын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага, Ром хот.
- Хардакер, Ж.Б., Хуйрнэ, Р. Б. М., Андэрсон, Ж. Р., ба Лиен, Ж. (2004). "Хөдөө Аж Ахуйн Эрсдэлийг Даван Түүлах," хоёрдох хэвлэл /Эд. КАБИ Хэвлэлийн газар, Их Британи улс.
- Холли Ванг, Х., Жанг, Я., ба Вү, Л. (2011). Хятад тариаланчдын хувьд гэрээт тариалан нь эрсдэлийн удирдлагын хэрэгсэл мөн үү? Шандонг мужийн хүнсний ногооны тариаланчдад хийсэн судалгааны үр дүн. *Хятадын Хөдөө Аж Ахуйн Эдийн Засгийн Тойм* 3, 489-505.
- Лю, Х. (2007). Гуаншин худалдан авагч - борлуулагчийн Хятад улсад гүйцэтгэх үүрэг. Жиангсү мужийн хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээнд хийсэн судалгаа, Вагенинген. Вагенингений Их Сургууль.
- Юуман, Л., Жисонг, С., Жанг, Х., ба Камфүис, Б. (2004). "Хятад улсын хүнсний ногооны салбар: Бодлого, үйлдвэрлэл, борлуулалт ба олон улсын худалдааны хөгжүүлэлт. ". Хөдөө Аж Ахуйн Эдийн Засгийн Хүрээлэн, Agricultural Economics Research Institute, Гаар хот.



Анхааруулга: Энэхүү бодлогын зөвлөмж бичгийг ХБНГУ-ын Холбооны Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам (ХХХААЯ)-ны хөрөнгө оруулалттай Герман-Монголын Хамтарсан Тогтвортой Хөдөө Аж Ахуй Төсөл (MNG 19-01) хариуцан гаргасан болно. Энд дурдсан үзэл бодол, үр дүн, дүгнэлт, дэвшүүлсэн санал эсвэл зөвлөмжүүд нь зохиогчдын өмч бөгөөд ХБНГУ-ын ХХХААЯ-ны үзэл бодлыг тусгаагүй болно.

Зохиогчид

Доктор. Ихтиёр Бобожонов
Эрдэм шинжилгээний ажилтан
Лейбницийн Шилжилтийн Эдийн
Засагтай Орнуудын ХАА-н Эдийн
Засгийн Хүрээлэн

Доктор. Лена Күнн
Эрдэм шинжилгээний ажилтан
Лейбницийн Шилжилтийн Эдийн
Засагтай Орнуудын ХАА-н Эдийн
Засгийн Хүрээлэн

Профессор. Доктор. Томас Глаубе.
Захирал
Лейбницийн Шилжилтийн Эдийн
Засагтай Орнуудын ХАА-н Эдийн
Засгийн Хүрээлэн